

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БНФУ	Бүгд найрамдах франц улс
ГХЯ	Гадаад харилцааны яам
МҮК	Монголын үндэсний комисс
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.УЯНГА ТАНАА

2020.02.24 № 06/570
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Төсвийн хөрөнгөөс 12,897.8 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Юнеско-ийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зардалд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ноос 2020 оны 2 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Б энд С аудит ХХК-ийн захирал Д.Дашхорлоо, чанарын хяналтын менежер Э.Дэлгэрцэцэг, ахлах аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах Ц.Дөлгөөн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн МҮК/20/33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын үйл ажиллагааны эрхэм зорилго нь үндэсний хууль тогтоомж, ЮНЕСКО-ийн дүрэм, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим хэм хэмжээг удирдлага болгон Монгол, Юнеско-ийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино. Комисс нь:

Үйл ажиллагааны чиглэл: Юнеско-ийн Монголын үндэсний комиссын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйл ажиллагаанд монголын эрх ашгийг эрхэмлэн улс орны эдийн засаг, нийгмийн салбарт тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд нэмэр хандив оруулахыг чармайна
- Юнеско-ийн үйл ажиллагаанд Монгол улсын идэвхитэй оролцоог хангаж боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн салбарт түүний бүсийн төвүүд, үндэсний байгууллагатай хамтын ажиллагааг зохицуулна
- Монгол орны түүх соёлын өв, дурсгалт зүйл, байгалийн өвөрмөц тогтоц, үнэт ховор баялаг, нөөцийг хайрлан арвижуулах, нөхөн сэргээх талаар ЮНЕСКО, түүний гишүүн орнуудтай нягт хамтран ажиллах чиглэлийг удирдлага болгоно
- Дэлхий нийтийн боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийг хөгжүүлэхэд чиглэсэн бүхий үйл ажиллагааг идэвхитэй дэмжин улс түмний ойлголцол итгэлцлийг нэмэгдүүлэхэд тус төхөм үзүүлнэ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн шатлал
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Юнеско-ийн Монголын үндэсний комисс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Юнеско-ийн Монголын үндэсний комиссын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 274,631.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2,746.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,332.2 мянган төгрөгөөр тогтоосон нь суурь үзүүлэлтийн дүнг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 306,313.0 мянган төгрөгөөр буюу 5.6 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,206.0	2,206.0
Авлага	40,035.5	49,592.1	9,556.6
Урьдчилгаа		132,373.7	132,373.7
Бараа материал	9,377.3	16,254.0	6,876.7
Үндсэн хөрөнгө	17,643.8	172,943.9	155,300.1
Нийт хөрөнгө	67,056.7	373,369.7	306,313.0
Өр төлбөр	40,385.4	50,175.2	9,789.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	26,671.3	323,194.5	296,523.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	67,056.7	373,369.7	306,313.0

Авлага дансны үлдэгдэл 9,556.6 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл татан төвлөрүүлснээс шалтгаалжээ. Тайлант оны татан төвлөрүүлэлт 49,356.9 мянган төгрөг, цалин хөлс буруу бодсоноос хувь хүмүүсээс авах авлага 235.3 мянган төгрөг, татвараас авах авлага 676.4 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

2019 онд ЮНЕСКО-ийн Парис дах төвөөс оролцооны 4 хөтөлбөр хэрэгжиж, энэхүү хөтөлбөрт хамрагдан 179,673.7 мянган төгрөгийн төсөл хэрэгжихээс 47,300.0 мянган төгрөгийн тооцоо хийгдэж, 132,373.7 мянган төгрөгийн үлдэгдэл урьдчилж төлсөн зардал дансанд тусгагдсан болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,876.7 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд ЮНЕСКО-той холбоотой гарын авлага, ном, товхимол хэвлэгдэж, зар сурталчилгаа, олон улсын сургалт семинарт тараан түгээгдсэн материалын үлдэгдэл мөн 2020 оны сургалт

семинарт зориулсан 8 нэр төрлийн 500 гаруй гарын авлага, товхимлууд тараах материалын үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн А-1/3874 албан тоотын дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 166,996.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 18.2 мянган төгрөгийн хангамжийн материал данс бүртгэлд хүлээн авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь төсөл арга хэмжээтэй холбоотой гэрээт ажлын үлдэгдэл байгууллагад өгөх өглөг 48,680.5 мянган төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 1,271.9 мянган төгрөг, ажилтан албан хаагчтай холбоотой 222.7 мянган төгрөгийн өр төлбөр байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 33 хөтөлбөрт зориулан 166,885.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 165,779.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 1,105.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 165,779.9 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь унаа хоолны хөнгөлөлт 739.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, энэ нь ажилтны өвчтэй, чөлөөтэй байсан хугацаа болон ээлжийн амралтаа авсан зэргээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Юнеско, юнеско-ийн бээжин дэх төлөөлөгчийн газраас ЮНЕСКО-ийн МҮК нь 2019 онд ЮНЕСКО-ийн Парис дахь төв, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-ийн Бангкок дахь төлөөлөгчийн газар болон бусад байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу 770,207.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хүлээн авсан. Мөн БНФУ-ын Парис хотноо ЮНЕСКО-ийн тайзнаа 70 орчим хүний бүрэлдэхүүнтэй “Хөмөргөн гурвалжин” этно бүжгэн жүжиг, “Монголын сая өдөр” фото зургийн үзэсгэлэнг ГХЯ, БСШУЯ, Соёл урлагийн газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, Соёл урлагийн их сургууль зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулах хүрээнд бусад байгууллагаас шилжүүлсэн орлого 74,316.5 мянган төгрөг нийт 844,524.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нийт 795,843.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 48,680.5 мянган төгрөгийг Сангийн яамны төрийн санд татан төвлөрүүлж, урсгал данснаас 1,105.9 мянган төгрөг нийт 49,801.4 мянган төгрөгийг төрийн сантай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 137,850.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 113,311.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,897.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 11,641.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 24,539.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 12,897.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг орчуулснаас дарга болон ажилтнуудад 12,897.8 мянган төгрөгийг олгосон.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 11,641.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсвийн зарцуулалтанд тавих хяналт, хууль эрх зүйн хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 14 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 420.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 14,559.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Байгууллагын авто машины засвар үйлчилгээний зардал 1,661.2 мянган төгрөгийг зарцуулахдаа машины техник ашиглалтын паспортыг хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралттай нийцээгүй, үнэн зөв байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.1.3. Өгсөн зөвлөмж: Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, авто машины хувийн хэргийг үнэн зөв хөтөлж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2019 оны машины техник ашиглалтын паспортыг тухай бүрд хөтөлж байсан бөгөөд машин техник ашиглалтын паспортууд дээр бичилт хийгдсэн ч үнийн дүн тавигдаагүй байсныг нөхөж бичив.

3.2. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт: Гэрээт ажил үйлчилгээтэй холбоотой ажлын тайлан байхгүй, гэрээ байгуулсан боловч гэрээ дүгнээгүй, зарцуулсан мөнгөний зориулалт тодорхойгүй, дотоод хяналт сул, төрийн албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу архивын нэгж үүсгээгүй, санхүүгийн баримтыг бүрдүүлж бүрэн архивлаагүй байна. Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан

зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид дарга, нягтлан бодогч нарын санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, жилийн худалдан авалтын дүнг тооцож ТБОНӨХБАҮХА тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан журмыг хэрэгжүүлж ажиллах, гэрээ дүгнэх, мөнгөн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, томилолтын баримт, үйл ажиллагааны зардалтай холбоотой мөнгөний зарцуулалтад тухайн ажлын тайланг хавсаргах шаардлагатай байна.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид дарга, нягтлан бодогч нарын санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, жилийн худалдан авалтын дүнг тооцож ТБОНӨХБАҮХА тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан журмыг хэрэгжүүлж ажиллах, гэрээ дүгнэх, мөнгөн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, томилолтын баримт, үйл ажиллагааны зардалтай холбоотой мөнгөний зарцуулалтад тухайн ажлын тайланг хавсаргаж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,412,859.54	200,425,845.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,206,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	2,206,000.00
31130	Нэмэлт санхүүжилт		2,206,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	40,035,558.84	49,592,144.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,000.00	
33300	Татаас, санхүүжилтийн авлага	38,180,514.24	
335	Бусад авлага	1,853,044.60	49,592,144.26
3351	Байгууллагаас авах авлага	1,841,400.00	49,356,871.70
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11,644.60	235,272.56
34	УРЬДЧИЛГАА	-	132,373,696.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	132,373,696.00
34714	Томилолтын урьдчилгаа		132,373,696.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,377,300.70	16,254,005.70
354	Хангамжийн материал	9,377,300.70	16,254,005.70
35410	Бичиг хэргийн материал	495,186.00	999,716.00
35440	Түлш, шатах тослох материал	529,071.03	811,187.03
35470	Бусад хангамжийн материал	8,353,043.67	14,443,102.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,643,824.76	172,943,906.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,643,824.76	172,943,906.29
392	Биет хөрөнгө	17,643,824.76	172,943,906.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,000,000.00	55,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	45,375,000.09	55,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,541,380.00	79,147,954.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	29,133,303.33	30,955,503.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,575,147.00	89,575,147.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	18,606,452.88	18,849,365.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,910,821.00	56,300,941.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	2,536,266.94	2,542,766.98
39217	Ном	267,500.00	267,500.00
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	770,000.00	770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	67,056,684.30	373,369,752.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	40,385,409.15	50,175,197.79
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,385,409.15	50,175,197.79
413	Өглөг	40,385,409.15	50,175,197.79
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		222,754.00
4136	Бусад өглөг	40,385,409.15	49,952,443.79
41361	Байгууллагад төлөх өглөг	38,180,514.24	48,680,550.73
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	918,178.89	1,271,893.06
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	33,802.25	
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	1,252,913.77	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,671,275.15	323,194,554.46
51	Засгийн газрын хувь оролцоо	26,671,275.15	323,194,554.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	78,398,015.00	78,398,015.00
512	Хуримтлагдсан үр дүн	(51,726,739.85)	244,796,539.46
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,680,241.46)	(51,726,739.85)
51220	Тайлант үеийн үр дүн	(37,046,498.39)	296,523,279.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	67,056,684.30	373,369,752.25

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	995,812,426.60	1,129,744,416.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	424,645,713.30	167,014,934.00
120	Нийтлэг татварын бус орлого	424,645,713.30	167,014,934.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	167,014,934.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	167,014,934.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	571,166,713.30	962,729,482.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	146,521,000.00	166,885,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	146,521,000.00	166,885,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	424,645,713.30	795,843,682.56
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	424,645,713.30	795,843,682.56
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	608,213,211.69	833,221,137.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	608,213,211.69	833,221,137.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,971,841.81	824,798,781.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,962,045.55	100,002,537.52
210101	Үндсэн цалин	65,760,231.12	72,743,537.96
210102	Нэмэгдэл	11,820,271.57	16,352,699.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,381,542.86	10,906,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,536,095.51	12,439,514.58
210201	Тэтгэврийн даатгал	6,679,092.01	8,553,214.63
210202	Тэтгэмжийн даатгал	1,022,050.34	837,427.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	866,587.93	811,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	157,795.40	215,369.15
210205	Эрүүл мэндийн даатгал	1,810,569.83	2,022,503.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,955,597.26	10,978,015.29
210304	Байрны түрээс	8,955,597.26	10,978,015.29
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	5,378,262.40	6,434,725.53
210401	Бичиг хэрэг	1,060,990.00	1,445,056.00
210402	Тээвэр, шатахуун	3,283,819.48	3,795,121.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,033,452.92	1,194,548.53
2107	Томилолт, зочны зардал	437,873.99	435,800.00
210702	Дотоод албан томилолт	246,700.00	246,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	191,173.99	189,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,516,242.61	22,404,909.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	8,199,442.61	20,968,409.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	194,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	481,185,724.49	672,103,278.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	463,154,468.67	660,406,666.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	18,031,255.82	11,696,612.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,241,369.88	8,422,355.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,301,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,301,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,241,369.88	1,120,855.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,241,369.88	1,120,855.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	387,599,214.91	296,523,279.31
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	387,599,214.91	296,523,279.31

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	609,347,227.54	1,855,964,266.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	844,539,233.29
120	Нийтлэг татварын бус орлого	-	844,539,233.29
120009	Бусад орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	609,347,227.54	1,011,425,033.29
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	146,521,000.00	166,885,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	146,521,000.00	166,885,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	462,826,227.54	844,539,233.29
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	462,680,784.66	844,539,233.29
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,442.88	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	609,347,227.54	1,009,219,033.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609,347,227.54	1,009,219,033.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	567,925,343.42	952,116,127.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,686,146.12	100,611,914.48
210101	Үндсэн цалин	64,484,331.69	73,341,914.48
210102	Нэмэгдэл	11,820,271.57	16,352,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,381,542.86	10,917,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,536,095.51	12,439,514.58
210201	Тэтгэврийн даатгал	7,221,800.00	8,553,214.63
210202	Тэтгэмжийн даатгал	902,700.00	837,427.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	722,200.00	811,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	131,561.79	215,369.15
210205	Эрүүл мэндийн даатгал	1,557,833.72	2,022,503.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,578,100.00	10,578,100.00
210304	Байрны түрээс	10,578,100.00	10,578,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,446,642.26	5,505,055.77
210401	Бичиг хэрэг	870,020.00	908,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,233,200.00	3,233,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,343,422.26	1,363,055.77
2107	Томилолт, зочны зардал	751,903.99	752,100.00
210702	Дотоод албан томилолт	246,700.00	246,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	505,203.99	505,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	23,277,827.52	23,587,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,961,027.52	22,150,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	194,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,648,628.02	798,642,242.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	429,648,628.02	798,642,242.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,421,884.12	57,102,906.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,301,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		7,301,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,421,884.12	49,801,406.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,421,884.12	49,801,406.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	846,745,233.29
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	846,745,233.29
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,206,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,398,015.00	-14,680,241.46		63,717,773.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,398,015.00	-14,680,241.46	0.00	63,717,773.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн		-37,046,498.39		-37,046,498.39
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,398,015.00	-51,726,739.85	0.00	26,671,275.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,398,015.00	-51,726,739.85	0.00	26,671,275.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн		296,523,279.31		296,523,279.31
D09	2019 оны 06-р сарын 30-нээрх үлдэгдэл	78,398,015.00	244,796,539.46	0.00	323,194,554.46

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	166,885,800.00	165,779,944.53	1,105,855.47	99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,885,800.00	165,779,944.53	1,105,855.47	99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,584,300.00	158,478,444.53	1,105,855.47	99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,366,200.00	100,611,914.48	754,285.52	99
210101	Үндсэн цалин	73,356,800.00	73,341,914.48	14,885.52	100
210102	Нэмэгдэл	16,352,700.00	16,352,700.00	-	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,656,700.00	10,917,300.00	739,400.00	94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтг	12,670,800.00	12,439,514.58	231,285.42	98
210201	Тэтгэврийн даатгал	8,616,100.00	8,553,214.63	62,885.37	99
210202	Тэтгэмжийн даатгал	856,800.00	837,427.57	19,372.43	98
210203	ҮОМШӨ-ний даатгал	967,800.00	811,000.00	156,800.00	84
210204	Ажилгүйдлийн даатгал	202,800.00	215,369.15	(12,569.15)	106
210205	Эрүүл мэндийн даатгал	2,027,300.00	2,022,503.23	4,796.77	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,578,100.00	10,578,100.00	-	100
210304	Байрны түрээс	10,578,100.00	10,578,100.00	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	5,505,200.00	5,505,055.77	144.23	100
210401	Бичиг хэрэг	908,800.00	908,800.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	3,233,200.00	3,233,200.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,200.00	1,363,055.77	144.23	100
2107	Томиллолт, зочны зардал	752,100.00	752,100.00	-	100
210702	Дотоод албан томиллолт	246,700.00	246,700.00	-	100
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	505,400.00	505,400.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,687,200.00	23,587,200.00	100,000.00	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	22,150,700.00	22,150,700.00	-	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	1,000,000.00	100,000.00	91
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,024,700.00	5,004,559.70	20,140.30	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,024,700.00	5,004,559.70	20,140.30	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,301,500.00	7,301,500.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,301,500.00	7,301,500.00	-	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэт	7,301,500.00	7,301,500.00	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	166,885,800.00	165,794,944.53	1,090,855.47	99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	166,885,800.00	165,779,944.53	1,105,855.47	99
131001	Улсын төсвөөс санхүүжих	166,885,800.00	165,779,944.53	1,105,855.47	99
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	15,000.00	(15,000.00)	
145005	бусад орлого	-	15,000.00	(15,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,206,000.00		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.20	Аудитын нэр: Юнескогийн Монголын үндэсний комиссын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код: САГ-2020/57/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Юнескогийн Монголын үндэсний комисс	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын машины засвар үйлчилгээний зардлыг зарцуулахдаа машины техник ашиглалтын паспортыг хөтлөөгүй байна.	1,661.2	Зөвлөмж өгсөн	Дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга Л.Буянхишиг
2	Гэрээт ажил үйлчилгээтэй холбоотой ажлын тайлан байхгүй, гэрээ байгуулсан боловч гэрээ дүгнээгүй, зарцуулсан мөнгөний зориулалт тодорхойгүй, дотоод хяналт сул, төрийн албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу архивын нэгж үүсгээгүй, санхүүгийн баримтыг бүрдүүлж бүрэн архивлаагүй байна.	0	Зөвлөмж өгсөн	Дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга Л.Буянхишиг
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг орчуулснаас дарга болон ажилтнуудад мөнгө олгосон	12,897.8	Албан шаардлага хүргүүлэв	Дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга Л.Буянхишиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/27

Улаанбаатар хот

С.М. 2020/57/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг орчуулсан ажлын хөлсийг тухайн байгууллагын ажилтнуудад олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Юнеско-ийн Монголын үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга, нягтлан бодогч Л.Буянхишиг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР П.ЧАНЦАЛДУЛАМ

"Б ЭНД С АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР Д.ЗАЯАЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:
ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.УЯНГА

НЯГТЛАН БОДОГЧ

Л.БУЯНХИШИГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Alban Shaardлага\2020\0228SAG7.Docx

001080100

